



# МЭДЭЭЛЛИЙН ТОВХИМОЛ

---

2026 ОН  
I-Р УЛИРАЛ



## ШҮҮХИЙН АКАДЕМИ 2026 ОНД ШҮҮГЧ-СУДЛААЧААР АЖИЛЛАХ ШҮҮГЧ НАРЫГ ХҮЛЭЭН АВЛАА

Шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын 24 дүгээр зүйлийн 24.7-д заасны дагуу зөвлөгөөн болон шүүгчийн өөрийн саналыг үндэслэн, Шүүхийн ерөнхий зөвлөлтэй зөвшилцсөний үндсэн дээр анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгчийг зургаан сар хүртэл хугацаагаар Шүүхийн академид судлаачаар ажиллуулж болох эрх зүйн зохицуулалттай.

**Энэхүү эрх зүйн зохицуулалтын хүрээнд шүүгч-судлаачаар ажиллах хүсэлтээ ирүүлсэн шүүгч нараас:**

Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч **Г.Урангуа**

Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч **Н.Дамдинсүрэн**



Дүүргийн Эрүү, Иргэний хэргийн хялбар ажиллагааны анхан шатны тойргийн шүүхийн шүүгч **Б.Дуламсүрэн**

Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны тойргийн шүүхийн шүүгч **С.Батгэрэл** нар сонгогдон шүүгч-судлаачаар ажиллахаар шийдвэрлэсэн юм.

## “ДОКТОР-ШҮҮГЧ” МЭДЛЭГ ХУВААЛЦАХ ЧӨЛӨӨТ УУЛЗАЛТ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Шүүхийн академиас санаачлан, шүүн таслах ажиллагаа хэрэгжүүлж буй нийт шүүгчдээс Хууль зүйн шинжлэх ухааны салбарт докторын зэрэг хамгаалсан шүүгч нарын судалгааны ажлын үр дүнг, олон нийтэд түгээх зорилгоор “ДОКТОР-ШҮҮГЧ” мэдлэг хуваалцах чөлөөт уулзалтыг цувралаар зохион байгуулж эхэллээ.

Эхний уулзалт 2026 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр болж, зочноор Монгол Улсын дээд шүүхийн шүүгч, Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн, доктор (Ph.D) гавьяат хуульч, Ч.Хосбаяр оролцон “Авлигын эсрэг олон улсын эрх зүйн хэм хэмжээг Монгол Улсын эрүүгийн хэргийн шүүхэд хэрэглэх үндсэн асуудал” докторын судалгааны ажлаа танилцууллаа.

Улсын дээд шүүхийн шүүгч, Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн, доктор (Ph.D) Ч.Хосбаяр докторын судалгааны ажлын хүрээнд Авлигын эсрэг Олон улсын конвенцыг тайлбарлан хэрэглэж, хэрэг маргааныг шийдэж буй 20 орчим улсын 420 гаруй шүүхийн шийдвэрийг судлан, дүн шинжилгээ хийжээ. Манай улсад олон улсын авлигын эрх зүйн орчноос зөрүүтэй хууль тогтоомжийн тогтолцоо бүрдсэнээс болж, авлигын гэмт хэргийн гаралт буурахгүй байгаа төдийгүй, эдгээр гэрээнүүдийг зөвхөн хэл зүйн талаас орчуулан хэрэглэж байгаа нь эрх зүйн ач холбогдол бүхий зарчим, ойлголтыг зарим байдлаар гээгдүүлснийг тодотгов. Мөн Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22 дугаар бүлгийг Олон Улсын конвенцоос хөрвүүлэхдээ гэмт хэргийн шинжүүдийг давхардуулах, объектив болон субъектив байдлын байрыг сольсноос болоод гэмт хэргийн шинжүүд хоорондоо төстэй болж, аль алианаар нь зүйлчилж буйг



анхаарах хэрэгтэй ба Авлигын эсрэг олон улсын эрх зүйн орчныг зөвхөн эрүүгийн эрх зүйн арга хэмжээгээр биш, сахилгын, иргэний, захиргааны эрх зүйн хүрээнд тэмцэх шаардлагатай ба зарим хууль, тогтоомжуудад оруулах санал, зөвлөмж дэвшүүлснээ танилцууллаа.



## **“Кибер орчинд үйлдэгдсэн хүн худалдаалах гэмт хэргийг шийдвэрлэхэд анхаарах зарим асуудал” сургалт боллоо**

Шүүхийн академи Азийн сантай хамтран зохион байгуулж буй “Кибер орчинд үйлдэгдсэн хүн худалдаалах гэмт хэргийг шийдвэрлэхэд анхаарах зарим асуудал” сэдэвт сургалт болж өндөрлөлөө.

Сургалтыг сургагч багш нар Кибер орчинд үйлдэгдсэн хүн худалдаалах гэмт хэргийн үндсэн ойлголт, онцлог, Тоон ул мөр ба цахим /дигитал/ нотлох баримт, Кибер орчинд үйлдэгдсэн хүн худалдаалах гэмт хэргийн цахим нотлох баримт, Кибер орчинд үйлдэгдсэн хүн худалдаалах гэмт хэргийн зүйлчлэлийн асуудал сэдвийн хүрээнд удирдан явууллаа.



## **Хяналтын шатны шүүхийн шүүгчдэд зориулсан “Санхүүгийн менежмент”-ийн сургалт боллоо**

Шүүхийн академи, Санхүү Эдийн Засгийн Их сургууль хамтран зохион байгуулж буй хяналтын шатны шүүхийн шүүгчдэд зориулсан “Санхүүгийн менежмент”-ийн сургалтад Улсын дээд шүүхийн Захиргаа болон Иргэний хэргийн танхимын шүүгчид хамрагдлаа.

Сургалт хоёр өдөр үргэлжлэх бөгөөд Санхүүгийн тайлангууд, тэдгээрт хийх санхүүгийн шинжилгээний суурь ойлголтууд, Санхүүгийн тайлангууд, тэдгээрт хийх санхүүгийн шинжилгээний суурь ойлголтууд зэрэг сэдвийн хүрээнд удирдан явуулсан юм.

## **Монголын Олон Улсын Арбитрын байгууллагатай хамтран ажиллах талаар санал солилцлоо**

Шүүхийн академийн захирал Д.Эрдэнэчимэг тэргүүтэй төлөөлөгч нар Монголын Олон Улсын Арбитрын Ерөнхий нарийн бичгийн дарга М.Шинэбаяр болон АНУ-ын Арилжааны эрх зүйн хөгжлийн хөтөлбөр (CLDP)-ийн Олон улсын хууль зүйн зөвлөх Гришма Прадхантай уулзлаа.

Уулзалтын үеэр хоёр байгууллага хамтын ажиллагааны талаар санал солилцон, хамтарсан хэлэлцүүлэг зохион байгуулах талаар Сургалтын хөтөлбөрийн хороогоор хэлэлцүүлэхээр тохиролцов.





## “Доктор-шүүгч” хоёр дахь удаагийн мэдлэг хуваалцах чөлөөт уулзалт боллоо

Шүүхийн академиас санаачлан хэрэгжүүлж буй “ДОКТОР-ШҮҮГЧ” мэдлэг хуваалцах чөлөөт уулзалтад Дүүргийн Эрүү, Иргэний хэргийн хялбар ажиллагааны анхан шатны тойргийн шүүхийн шүүгч, доктор (Ph.D) Нямдоржийн Одонтуул уригдан, “Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний эрх зүйн зохицуулалт, хэрэгжилт” докторын судалгааны ажлаа танилцуулж, нээлттэй хэлэлцүүлэг өрнүүллээ.

### ЭМНЭЛГИЙН ЧАНАРТАЙ АЛБАДЛАГЫН АРГА ХЭМЖЭЭНИЙ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ХЭРЭГЖИЛТ

2026 оны 1 дүгээр сар



Доктор (Ph.D) Н.Одонтуул Монгол Улсын хүн амын дундах сэтгэцийн эрүүл мэндийн өвчлөл, тархац өмнөх 30 жилтэй харьцуулахад мэдэгдэхүйц нэмэгдсэн бөгөөд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний эрх зүйн зарчим, эрүүгийн хариуцлагын нийтлэг асуудалтай уялдуулан судлаагүй, онолын хувьд шинжлэх ухааны үндэслэл бүхий хариулт өгөх шаардлага байгаа гэж үзжээ.



Монгол Улсын хувьд эрх зүйн зохицуулалт оновчтой бус, мансуурах болон согтуурах донтой хүмүүст ял оногдуулахын зэрэгцээ энэ төрлийн арга хэмжээг огт хэрэглэдэггүй гэсэн дүгнэлтийг хийсэн байна. Мөн хэрэг хариуцах чадварыг тогтоох нэгдсэн стандарт, шинжлэх ухааны үндэслэл бүхий нэр томьёо дутмаг, СЭМҮТ-ийн Шүүхийн сэтгэц эмгэг судлалын клиникийн байр, техник технологи, хүний нөөцийг бодлогын түвшинд шинэчлэх, сэтгэцийн эрүүл мэндийн цогц хөтөлбөр баталж, нийгэм, хамт олонд түшиглэсэн эмчилгээ, үйлчилгээний эрх зүйн орчныг бүрдүүлэх, “Албадан эмчлэх аюулгүй байдлын арга хэмжээ”-г илүү сайжруулах шаардлагатай зэрэг өөрийн дэвшүүлсэн санал, дүгнэлтээ танилцуулав.



## Шүүхийн академи Ханнс Зайделийн сангийн хамтын ажиллагааны талаар санал солилцлоо

Шүүхийн академийн захирал Д.Эрдэнэчимэг, ХБНГУ-ын Ханнс Зайделийн сангийн Солонгосын хойг болон Монгол дах Төлөөлөгчийн газрын суурин төлөөлөгч Феликс Гленк тэргүүтэй төлөөлөгчдийг хүлээн авч уулзлаа. Уулзалтаар талууд ирэх 3 жилийн хугацаанд хийж хэрэгжүүлэх ажлын талаар санал солилцов.

2026 онд хоёр байгууллага хамтын ажиллагааны хүрээнд шүүгч, судлаачдыг зочин судлаачаар ХБНГУ-д ажиллуулах, Хяналтын шатны шүүгч нарт зориулсан сургалт зохион байгуулах зэрэг ажлуудыг хамтран хэрэгжүүлэхээр тогтлоо. Мөн байгаль орчин уур амьсгалын өөрчлөлтийн хуулийн асуудлаарх шүүгчдийн олон улсын уулзалт, хэлэлцүүлгийг хамтран зохион байгуулахаар ярилцлаа.





## Шүүхийн академи Япон Улсын Хууль зүйн яамны Судалгаа, сургалтын хүрээлэнтэй хамтран ажиллах талаар санал солилцлоо

Шүүхийн академийн захирал Д.Эрдэнэчимэг, Сургалтын төвийн дарга Г.Халиунаа, Судалгааны төвийн дарга Б.Дөлгөөн нар Япон улсын Хууль зүйн яамны харьяа Сургалт, судалгааны хүрээлэнгийн төлөөллийг 2026 оны 02 дугаар сарын 04-ны өдөр хүлээн авч уулзлаа.

Уулзалтаар талууд Монгол Улсад Гэр бүл, хүүхдийн хэргийн дагнасан шүүх байгуулахтай холбоотойгоор Япон улсын гэр бүлийн шүүхийн сайн туршлага судлах, хамтран ажиллах талаар санал солилцсон юм. Мөн гэр бүлийн шүүхийн шүүгчдэд зориулсан мэргэшсэн сургалтын хөтөлбөр, сургалт, судалгаанд суурилсан хамтарсан төсөл, цаашид урт хугацааны хамтын ажиллагааны боломжуудын талаар хэлэлцлээ.




## Шүүгчийн сэтгэл зүйн эрүүл мэндийг дэмжих чиглэлээр хамтран ажиллах санамж бичиг байгуулав



Шүүхийн академи, Монголын Шүүгчдийн холбоо, Монголын сэтгэл зүйчдийн нийгэмлэг 2026 оны 2 дугаар сарын 6-ны өдөр хамтран ажиллах санамж бичиг байгуулж, энэхүү санамж бичигт Шүүхийн академийн захирал Д.Эрдэнэчимэг, Улсын дээд шүүхийн шүүгч, Монголын Шүүгчдийн холбооны тэргүүн Д.Батбаатар, Монголын сэтгэл зүйчдийн нийгэмлэгийн тэргүүн Ш.Батсүх нар гарын үсэг зурлаа.

Хамтын ажиллагааны хүрээнд талууд 2025 онд Монголын Шүүгчдийн холбооны санаачилгаар бэлтгэгдсэн сэтгэл зүйн сургагч-багш нарыг гүнзгийрүүлэн мэргэшүүлэх, 2026 оны 4 дүгээр сард шүүгчдийн сэтгэл зүйн эрүүл мэндийг дэмжих чиглэлийн сургалт зохион байгуулах, мөн Монголын сэтгэл зүйчдийн нийгэмлэгээс эрхлэн гаргадаг "Сэтгэл судлал таны амьдралд" цуврал сэтгүүлийн шүүгчдэд зориулсан тусгай дугаарыг хамтран гаргахаар боллоо.

## Сургагч багш бэлтгэх сургалт, Ерөнхий шүүгч нарын манлайллын хөтөлбөр хэрэгжүүлэхээр боллоо



Шүүхийн академи болон Канадын Үндэсний шүүхийн хүрээлэнгийн удирдлагууд өнөөдөр буюу 2026 оны 02 дугаар сарын 10-ны өдөр цахим уулзалт хийлээ.

Талууд Канад Улсын Холбооны Шүүхийн Хэрэг Эрхлэх Комиссарын газартай хамтран хэрэгжүүлж буй "Тэгш эрх, шударга ёсыг хүн бүрд" (EJAM) төслийн хамтын ажиллагааны хүрээнд 2026 оны 04 дүгээр сарын 13-17-ны өдрүүдэд Ерөнхий шүүгч болон Гэр бүлийн шүүхийн сургагч багш нарыг бэлтгэх сургалт, бүх шатны шүүхийн Ерөнхий шүүгч нарт зориулсан манлайллын хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр тохиролцлоо.



## “Шүүх хэвлэл мэдээлэлтэй харилцах нь” сэдэвт сургалтыг амжилттай зохион байгууллаа

Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн академи нь Европын Холбооны санхүүжилттэйгээр Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллага (IDLO) болон Twinning төсөлтэй хамтран “Шүүх эрх мэдлийн байгууллагын хамтын ажиллагаа ба ил тод байдал” (2024–2026) төслийн хүрээнд “Шүүх хэвлэл мэдээлэлтэй харилцах нь” сэдэвт сургалтыг 2026 оны 2 дугаар сарын 3-6-ны өдрүүдэд дөрвөн өдрийн турш амжилттай зохион байгууллаа.



Сургалтад ХБНГУ-ын Шлесвиг-Холштэйн мужийн Үндсэн хуулийн шүүхийн гишүүн бөгөөд Лүбек хотын анхан шатны шүүхийн шүүгч, Танхимын дарга Др.Марк Петит, мөн ХБНГУ-ын Мюнхен хотын Дээд мужийн шүүхийн шүүгч, Мэдээллийн албаны дарга Др.Лоран Лафлёр нар хүрэлцэн ирж, шүүх хэвлэл мэдээлэлтэй хамтран ажилладаг туршлага болон шүүх социал медиаг хэрхэн ашигладаг талаарх туршлага хуваалцсан юм.

Сургалтад нийт шүүхийн Ерөнхий шүүгч болон шүүхийн байгууллагын олон нийттэй харилцах чиглэлийн мэргэжилтнүүдээс бүрдсэн 100 гаруй оролцогч хамрагдаж, батламж гардан авлаа.

## 2026 онд зохион байгуулагдах сургалтын хөтөлбөрүүдийг хэлэлцлээ

Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн академийн Сургалтын хөтөлбөрийн хорооны ээлжит хуралдаан 2026 оны 2 дугаар сарын 11-ний өдөр боллоо.

Улсын дээд шүүхийн шүүгч, Захиргааны хэргийн танхимын тэргүүн Д.Мөнхтуяа 2026 онд захиргааны эрх зүйн чиглэлээр зохион байгуулагдах “Улсын дээд шүүхийн тайлбар, хууль хэрэглээний нэгдмэл байдал”, “Шүүхийн шийдвэр биелүүлэх арга, журмыг шүүхийн шийдвэрт тусгах асуудал”, “Шүүхийн шийдвэрт нөлөөлөхүйц хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ноцтой зөрчлүүдийг тодорхойлох асуудал”, “Санхүүгийн болон татварын маргаан шийдвэрлэхэд анхаарах асуудал: үнэ шилжилт” сургалтын хөтөлбөрүүдийг танилцуулж, гишүүдийн саналаар дэмжив.

Хөтөлбөрийн хорооны гишүүн Баян-Өлгий аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч С.Өмирбек, Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны тойргийн шүүхийн Ерөнхий

шүүгч Б.Дашдондов нар мөн онд эрүүгийн эрх зүйн чиглэлээр зохион байгуулагдах сургалтын хөтөлбөрүүдийг танилцуулж, гишүүд санал солилцов.

Тодруулбал, “Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээтэй холбоотой хууль хэрэглээний асуудал”, “Эрүүгийн хуулийг хэрэглэх онол, арга зүй, шүүхийн практик” (Эрүүгийн хуулийн тусгай ангийн 27.10 дугаар зүйлийн 5 дахь хэсэг), “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлтүүд — уялдаа, хэрэглээ” сургалтын хөтөлбөрүүдийг хэлэлцүүлж, гишүүд дэмжлээ.

Мөн Улсын дээд шүүхийн шүүгч, Иргэний хэргийн танхимын тэргүүн Г.Алтанчимэг 2026 онд Иргэний эрх зүйн чиглэлийн “Үүргийн эрх зүйн тулгамдсан асуудал” сэдэвт сургалтын хөтөлбөрийг танилцуулсан бол Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн академийн захирал Д.Эрдэнэчимэг Шүүгчийн мэргэжил ёс зүйн чиглэлээр “Шүүгчийн мэргэжлийн алдаа болон сахилгын зөрчлийн ялгаа, тэдгээрийн харилцан хамаарал”, мөн Ерөнхий шүүгчдэд зориулсан манлайлын сургалтын хөтөлбөрүүдийг танилцуулж, гишүүд дэмжин батлуулахаар санал нэгдлээ.



## БНСУ-ЫН ОЮУНЫ ӨМЧИЙН ШҮҮХИЙН ХАРЬЯА ОЛОН УЛСЫН ОЮУНЫ ӨМЧИЙН ЭРХ ЗҮЙН СУДАЛГААНЫ ТӨВТЭЙ ХАМТРАН АЖИЛЛАХ САНАМЖ БИЧИГ БАЙГУУЛЛАА

Шүүхийн академи, Бүгд Найрамдах Солонгос Улсын Оюуны өмчийн шүүхийн харьяа Олон улсын оюуны өмчийн эрх зүйн судалгааны төвтэй харилцан ойлголцлын санамж бичиг 2026 оны 02 дугаар сарын 27-ны өдөр цахимаар байгууллаа.

Санамж бичгийн хүрээнд Монгол улсаас жил бүр хоёр шүүгчийг Олон улсын оюуны өмчийн эрх зүйн судалгааны төвд судлаачаар ажиллуулах, шүүгч, судлаач, шүүхийн мэргэжилтнүүдийг харилцан солилцох, туршлага судлуулах, олон улсын хурал, симпозиум, эрдэм шинжилгээний хурлуудад төлөөлөгчдийг оролцуулахад харилцан дэмжлэг үзүүлэх, зочин судлаач солилцооны хөтөлбөр хэрэгжүүлэх, сургалтын хэрэглэгдэхүүн, орчуулгын үйлчилгээ болон бусад шаардлагатай мэдээллээр харилцан хангаж, эрх зүйн хүрээнд хамтран ажиллахаар тохиролцлоо.



## Анхан шатны шүүхэд шинээр томилогдсон шүүгчдийн сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгох сургалт боллоо

Европын Холбооны санхүүжилтээр хэрэгжиж буй Хосолмол түншлэлийн (Twinning) төсөл болон Шүүхийн академи хамтран “Анхан шатны шүүхэд шинээр томилогдсон шүүгчийг мэргэшүүлэн дадлагажуулах сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгох” сургалтыг 2026 оны 3 дугаар сарын 3-ны өдөр зохион байгууллаа.

Сургалтыг ХБНГУ-ын Хойд Райн-Вестфалиа мужийн Оберхаузен хот дахь анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч Кристиан Хаппе, мөн тус мужийн Дюссельдорф хотын Хууль зүйн яамны зөвлөх Элизабет Хартунг нар удирдан явуулсан юм.





## ХБНГУ-ЫН ТУРШЛАГЫГ ХУВААЛЦСАН СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА

ХБНГУ-ын Хойд Райн-Вестфалиа мужийн Оберхаузен хот дахь анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч Кристиан Хаппе, мөн тус мужийн Дюссельдорф хотын Хууль зүйн яамны зөвлөх, шүүгч Элизабет Хартунг нар 2026 оны 3 дугаар сарын 5-ны өдөр “Хэрэгцээнээс үр нөлөө - чанарыг баримталсан сургалтын загвар боловсруулах аргачлал” сэдвийн хүрээнд сургалт удирдан явууллаа.

Энэхүү сургалтыг Европын Холбооны санхүүжилтээр хэрэгжиж буй Хосолмол түншлэлийн (Twinning) төсөл болон Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн академи хамтран зохион байгуулж байгаа бөгөөд сургалтаар ХБНГУ-д сургалтын хөтөлбөрийг хэрэгцээнд суурилан, үр нөлөө болон чанарын шалгуурт нийцүүлэн боловсруулж, хэрэгжүүлдэг туршлагыг танилцуулж, хоёр улсын сургалтын хөтөлбөрийн онцлог, ялгааг хэлэлцэн, чанарын удирдлагын тогтолцооны талаар харилцан санал солилцов.



### Шүүгч А.Сарангэрэл: Энэ мэргэжил нь өндөр хариуцлага, шударга ёсны төлөөх тууштай байдлыг шаарддаг

Шүүхийн академиас Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч А.Сарангэрэл, Б.Адъяасүрэн нарыг Швейцарын Холбооны Улсын Женев хотноо 2025 оны 10 дугаар сард Дэлхийн Оюуны Өмч байгууллага (WIPO)-аас зохион байгуулсан Оюуны өмчийн шүүгчдийн форумд нэр дэвшүүлэн оролцуулсан билээ.



Улмаар шүүгч А.Сарангэрэлийг Дэлхийн Оюуны өмчийн байгууллагаас Дэлхийн эмэгтэй шүүгчдийн өдөрт зориулан ярилцлага өгч, туршлагаа хуваалцах шүүгчдийн нэгээр нэр дэвшүүлэн, дэлхийн өнцөг булан бүрд суугаа мэргэжил нэгтнүүддээ үзэл бодлоо хуваалцах боломжоор ханган ажиллалаа.

Шүүхийн академи Дэлхийн Оюуны өмчийн байгууллагатай хамтран 2024, 2025 онд шүүгчдэд зориулсан оюуны өмчийн анхан шатны алсын зайн сургалтыг зохион байгуулсан бөгөөд Монгол Улсаас нийт 88 шүүгч хамрагдаад байна.




2026 оны ээлжит сургалтыг ирэх 5-7 дугаар сард цахимаар, ахисан шатны сургалтыг 09 дүгээр сард Монгол Улсад танхимаар зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.



## “Монгол бичиг”-ийн мэдлэг олгох, дотоод сургалтыг цахимаар зохион байгууллаа

Шүүхийн академи нийт албан хаагчдадаа зориулсан “Монгол бичиг”-ийн мэдлэг олгох, дотоод сургалтыг 2025 оны 02 дугаар сарын 24-ний өдрөөс 03 дугаар сарын 11-ний өдрийн хооронд, цахим хэлбэрээр зохион байгууллаа.

Энэхүү сургалт нь 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд явагдсан юм. Уг хуульд төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллагууд албан хэргээ кирилл болон үндэсний монгол бичгээр хослуулан хөтлөхөөр заасан байдаг. Сургалтад хамрагдсан албан хаагчид үндэсний бичгийн онол, зүй болон албан хэрэг хөтлөлтөд ашиглах практик мэдлэг, чадвар эзэмшиж, сургалтын төгсгөлд батламж гардан авлаа.



## БНСУ-ын шүүхийн байгууллагын төлөөлөлтэй уулзлаа

Шүүхийн академийн захирал Д.Эрдэнэчимэг, Улсын дээд шүүхийн Тамгын газрын дарга С.Заяадэлгэр нар 2026 оны 3 дугаар сарын 18-ны өдөр БНСУ-ын Чонжу хотын орон нутгийн шүүхийн захиргааны ажилтан Ким Юн Гагтай уулзлаа.

2026 онд Хэнтий, Сэлэнгэ, Ховд, Завхан, Архангай, Төв аймагт шүүх байгуулагдсаны түүхт 100 жилийн ой тохиож байгаа бөгөөд Шүүхийн академи, Улсын дээд шүүх эдгээр аймгийн шүүхүүдтэй эрдэм шинжилгээний хурал, сургалт, шилдэг илтгэлийн уралдаан зэргийг хамтран зохион байгуулах юм.

Мөн Архангай, Сэлэнгэ аймгийн нэг сургуулийг сонгон дэмжлэг үзүүлэхээр болж цахим уулзалт хийлээ. Хоёр орны шүүгчид болон шүүхийн захиргааны ажилтнууд ЕБС-ийн сурагчдад зориулан хандивын арга хэмжээ, сайн дурын ажил хамтран зохион байгуулна.



## АНУ-ын Конгрессын Олон улсын манлайллын албаны /COIL/ сургалт, хөтөлбөрт шүүгчид хамрагдав



Монгол Улсын дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн Ч.Хосбаяр, Иргэний танхимын шүүгч Х.Эрдэнэсүвд, Шүүхийн академийн захирал Д.Эрдэнэчимэг, Монгол Улс дахь АНУ-ын ЭСЯ-ны Улс төрийн мэргэжилтэн М.Номинцэцэг тэргүүтэй төлөөлөгчид АНУ-ын Конгрессын Олон улсын манлайллын албаны сургалт, хөтөлбөрт 2026 оны 3 дугаар сарын 1-нээс 13-ны өдрүүдэд хамрагдлаа.

Улсын дээд шүүх болон Шүүхийн сургалт судалгаа мэдээллийн академи АНУ-ын Конгрессын Олон улсын манлайллын алба /COIL/-тай 2025 оны 06-р сард “Шүүхийн хараат бус байдал ба цахимжилт” олон улсын хурлыг Улаанбаатар хотноо амжилттай зохион байгуулж мөн оны 10-р сарын 15-ны өдөр АНУ-ын Вашингтон хотноо хамтран ажиллах санамж бичиг байгуулсан юм.

Энэхүү санамж бичгийн хүрээнд Улсын дээд шүүхийн Эрүү болон Иргэний танхимын нийт 11 шүүгч энэ удаагийн сургалт, хөтөлбөрт хамрагдав.





## Япон Улсын Нагояагийн Их Сургуулийн төлөөлөлтэй уулзлаа

Шүүхийн академийн захирал Д.Эрдэнэчимэг 2026 оны 3 дугаар сарын 19-ний өдөр Япон Улсын Нагояагийн Их Сургуулийн Азийн эрх зүйн солилцооны төвийн захирал, профессор Мураками Масако тэргүүтэй төлөөлөгч нарыг хүлээн авч уулзлаа.

Талууд хамтын ажиллагааны санамж бичгийн хүрээнд хэрэгжүүлж буй сургалт, судалгаа, эрдэм шинжилгээний ажлыг цаашид өргөжүүлэн хөгжүүлэх боломж, сэдвийн ач холбогдлын талаар дэлгэрэнгүй санал солилцов.

Мөн Хяналтын шатны шүүгчдийн заавал судлах сургалтын хүрээнд “Гэм хор ба хариуцлага” сэдвээр сургалт зохион байгуулах болон Олон улсын эрдэм шинжилгээний хуралд Япон Улсын шүүхийн байгууллагын оролцоог хангах боломж нөхцөлийн талаар ярилцлаа.



## Анхан шатны шүүхэд шинээр томилогдсон шүүгчийг мэргэшүүлэх сургалт болж өндөрлөлөө

Шүүхийн академиас “Анхан шатны шүүхэд шинээр томилогдсон шүүгчийг мэргэшүүлэн дадлагажуулах” сургалтыг 2026 оны 3 дугаар сарын 16-ны өдрөөс 27-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулж өндөрлөлөө. Энэ удаагийн сургалт хууль тайлбарлан хэрэглэх онол, нотлох баримтыг үнэлэх, шүүхийн шийдвэр гаргах арга техник, шүүх хуралдаанд бэлтгэх, даргалах, мэтгэлцэх зарчмыг хэрэгжүүлэх, хэргийн хөдөлгөөний удирдлага, маргаан шийдвэрлэх бусад хэлбэрүүд, хялбаршуулсан журмаар болон шүүхийн бус журмаар маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа зэрэг өргөн хүрээний сэдвүүдээр явагдсан юм.

## Төв аймагт шүүх байгуулагдсаны түүхт 100 жилийн ойг тохиолдуулан Монгол Улсын Гавьяат хуульч Ч.Доржгочоо, М.Могноон нарын нэрэмжит “Шилдэг илтгэл” шалгаруулах уралдааны шилдгүүд тодорлоо

Төв аймагт шүүх байгуулагдсаны түүхт 100 жилийн ойг тохиолдуулан Монгол Улсын Гавьяат хуульч Ч.Доржгочоо, М.Могноон нарын нэрэмжит “Шилдэг илтгэл” шалгаруулах уралдааны шагнал гардуулах ёслол 2026 оны 3 дугаар сарын 27-ны өдөр зохион байгуулагдлаа.

Энэхүү арга хэмжээг Шүүхийн академи хамтран зохион байгуулсан бөгөөд шалгарсан илтгэлүүдийг “Монголын шүүх, эрх зүй судлал” сэтгүүлд хянан магадалгаагаар зөвшөөрөгдсөн тохиолдолд хэвлэх юм. Арга хэмжээг Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн академийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга Б.Дөлгөөн хааж, оролцогчдын цаашдын сурлага, хөдөлмөрт амжилт хүсэв.

